



45

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 17 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/18

Баянгол

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх,
эрүүлжүүлэх арга хэмжээг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.4, 4.5.6, 4.5.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж явуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, хугацааг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг хугацаанд нь чанартай зохион байгуулж вакцин тарьсан жагсаалтыг мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчаар хянуулж, дүгнэлт гаргуулж аймгийн Үйлдвэр хөдөө аж ахуйн газарт хугацаанд нь хүргүүлж ажиллахыг малын эмч Ч.Нарантуяа, Д.Алтанцэцэг, Ж.Баасан, Г.Сайнхүү нарт үүрэг болгосугай.

3. Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийн хяналт шалгалтаар халдварт өвчний вакцин тариагүй болон вакцин тарьсан өрхийн малд халдварт өвчин гарсан тохиолдолд санхүүжилт олгохгүй болохыг мал эмнэлэг үржлийн үйлчилгээний нэгжийн малын эмч нарт мэдэгдсүгэй.

4. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг туслалцаа үзүүлж, зар мэдээлэл хүргэх, хуц ухныг хээлтүүлгийн бус үед бүрэн ялгуулж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээнд малыг тогтоосон хугацаанд нь бүрэн хамруулаагүйн улмаас гарсан хохирлыг малчин, мал бүхий иргэн өөрөө хариуцахыг мэдэгдсүгэй.

6. Мал эмнэлгийн арга хэмжээнд мал сүргийг бүрэн хамруулах, тарилга туулгалт, угаалга, боловсруулалт, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлын явцад хяналт шалгалт хийж зөрчил гарсан тохиолдолд холбогдох хуулийн дагуу арга

2.

хэмжээ тооцох, зохион байгуулсан ажлын дүн мэдээг 2017 оны 10 дугаар сарын 10-ны дотор Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг Мал эмнэлэг үржлийн тасгийн дарга /Х.Даваацэрэн/, мэргэжилтэн /Б.Гантулга/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



М. ТУНГАЛАГТАМИР

47
Сумын Засаг даргын 2017 оны 05 дугаар
сарын 01 -ны өдрийн 4/8 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

МАЛ ЭМНЭЛГИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга: Х.Даваацэрэн /МЭҮТ-ийн дарга/

Гишүүд: Б.Гантулга /МЭҮТ-ийн мэргэжилтэн/

Ч.Нарантуяа /"Гурван Богд Хайрхан" МЭҮҮН/

Д.Алтанцэцэг /"Индэртийн өгөөж" МЭҮҮН/

Ж.Баасан /"Дархан халтар" МЭҮҮН/

Г.Сайнхүү /"Тунгалаг-Рашаант" МЭҮҮН/

48

Сумын Засаг даргын 2017 оны 05 дугаар
сарын 01 -ны өдрийн 4/18 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

№	Багийн нэр	Халдварт өвчний вакцин тарих, туулгалт хийх, хагас жилийн тайлан өгөх		Рев-1, ШТАМ-19 вакцин тарих угаалга хийх, жилийн эцсийн тайлан өгөх	
		Тарих хугацаа	Мэдээ ирүүлэх хугацаа	Тарих хугацаа	Мэдээ ирүүлэх хугацаа
1.	Баянгол	2017.05.02	2017.06.19	2017.08.01	2017.09.10
2.	Хамтын хүч	2017.05.02	2017.06.19	2017.08.01	2017.09.10
3.	Сондуулт	2017.05.02	2017.06.19	2017.08.01	2017.09.10
4.	Улаантуг	2017.05.02	2017.06.19	2017.08.01	2017.09.10



49

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 17 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/19

Баянгол

Зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", 29.2, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.7 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Р.Оюунчимэг /ЗДТГ-ын дарга/

Гишүүд: Б.Хорлоожав /Нийгмийн даатгалын байцаагч/

Б.Гантулга /МЭҮТ-ийн мэргэжилтэн/

Б.Мөнхзаяа /Дүн бүртгэгч, бага эмч/

Х.Нарантуяа /Улаан загалмайн гишүүн/

Н.Содной /Үйлдвэрчний эвлэлийн дарга/

Б.Баярмаа /Баянгол багийн иргэн/

2. Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллахыг зөвлөлийн бүрэлдэхүүнд даалгасугай.

ОРЛОГЧ  Х.ТӨРТУЛГА





**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ШАРГА СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/20

Баянгол

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Х.Төртулга /Засаг даргын орлогч/

Гишүүд: Э.Тогтбаатар /Алтай-Улиастай ЭХСТӨК-ий салбарын эрхлэгч/

Б.Оюунтүлхүүр /Байгаль орчны хяналтын улсын байцаагч/

Г.Ган-Очир /Баянгол багийн Засаг дарга/

О.Зинээзэг /Холбооны эрхлэгч/

М.Золбаяр /Сургуулийн захирал/

Ж.Хишигжаргал /ЭМТ-ийн их эмч/

Г.Ариунбаяр /ИТХ-ын төлөөлөгч/

Х.Төмөрбаатар /ИТХ-ын төлөөлөгч/

Б.Гэрэлт-Од /Газрын даамал/

2. Төлөвлөгөөг боловсруулах тендерт шалгарсан “Инженер геодези” ХХК-тай хамтран иргэдийн оролцоог ханган зохион байгуулахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.ТУНГАЛАГТАМИР